

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлаас 2019 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаа нь эрх мэдлийн харилцан хяналттай, тогтвортой, хариуцлагатай, эрх зүйт төрийг төлөвшүүлэхэд чиглэгдсэн. Үүний хүрээнд Улсын Их Хурлаас Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 онд батлан хэрэгжүүлж байна. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 3 дугаар зүйлд Монгол Улсын Их Хурлын үндсэн зорилт, чиг үүрэг, бүрэн эрх, зарчмыг тусгасан бөгөөд хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т "... цөөнхийн саналыг хүндэтгэн асуудлыг олон талт үзэл бодлын үүднээс чөлөөтэй хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэнэ." гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын "Ухаалаг засаглал" зорилтын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх зорилтод "Улсын Их Хурлын хууль тогтоох, бодлого тодорхойлох, төлөөлөх, хяналт тавих чадавх сайжирч парламентын засаглал бэхэжсэн байна." гэсэн зорилт дэвшүүлсэн.

Улсын Их Хурлын 2019 оны 106 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөний *Хууль тогтоох үйл явцыг боловсронгуй болгож, парламентат ёсны шаардлагад нийцүүлэн, ард түмний хүсэл зориг, эрх ашгийг хангахад чиглүүлж, тэдний оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх стратегийн зорилтын хүрээнд 1.1.3-т "Улсын Их Хурал нь цөөнхийг хүндэтгэж, түүний үйл ажиллагаанд хуулийн хүрээнд дэмжлэг үзүүлж, Улсын Их Хурлын гишүүд, ажлын албаны ажилтнуудын ажиллах нөхцөл, боломжийг сайжруулах талаар анхаарч ажиллах;"*, Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх байнгын тогтолцоог бүрдүүлж чадавхжуулах стратегийн зорилтын хүрээнд 2.2.5-д "Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагаанд Улсын Их Хурал дахь цөөнхийн төлөөлөл, иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох;" арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан байна.

Эдгээр эрх зүйн баримт бичигт тусгагдсан зорилтууд нь энэ хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 дахь хэсэгт "28.6.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо Улсын Их Хуралд хамгийн олон удаа сонгогдсон таван гишүүнээс бүрдэх бөгөөд Улсын Их Хурлыг хугацаанаас нь өмнө тараах, гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах талаар энэ хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Улсын Их Хуралд ирүүлсэн саналыг судалж санал, дүгнэлт гарган зохих Байнгын хорооны болон нэгдсэн

хуралдаанд оруулна.” гэж заасан бөгөөд Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр сонгогдсон гишүүдээс хамгийн олон удаа сонгогдсон таван гишүүн нь аль нэг улс төрийн намаас сонгогдсон байх тохиолдол гарч байна.

Цөөнхийн төлөөллөөс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах асуудал хөндөгдсөн тохиолдолд аль нэг улс төрийн хүчнээс сонгогдсон гишүүд санал, дүгнэлт гарган Байнгын хорооны болон нэгдсэн чуулганд оруулж байгаагаас үүдэн тухайн Дэд хорооны гишүүдийг асуудалд бодитой хандсан эсэх, гаргаж буй санал, дүгнэлттэй нь холбогдуулан эргэлзэх хандлага цөөнхийн төлөөлөл болсон Улсын Их Хурлын гишүүдээс ч гарах тохиолдол байна.

Иймд Улсын Их Хурлыг хугацаанаас нь өмнө тараах, гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах талаар хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Улсын Их Хуралд ирүүлсэн саналыг судалж санал, дүгнэлт гаргах үүрэгтэй Улсын Их Хурлын халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд цөөнхийн төлөөллийг оролцуулах зарчим баримталдаг байх шаардлага үүссэн тул Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тус хуулийн 28 дугаар зүйлийн 28.6-д заасан Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд цөөнхийн төлөөллийг оролцуулах болон Улсын Их Хурлын гишүүнээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9.8 дахь хэсэгт заасан асуудлаар гаргасан гомдлыг судлан, шийдвэрлэх зохицуулалтыг тусгасан.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ